

СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ АРГА ЗҮЙ

Улс орны эдийн засаг, нийгмийн бүх хүрээг хамарсан шинэчлэлийн үйл явц амжилттай хэрэгжиж байгаа өнөө үед боловсролын салбарын шинэчлэл хүн амын боловсролын хэрэгцээг хангах орчин нөхцлийг бүрдүүлэх, бүх нийтээр суурь боловсрол эзэмших, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх тогтолцоог хувь хүний сонирхол, нийгмийн хэрэгцээ, зах зээлийн эрэлтэд нийцүүлэн хөгжүүлэх, орчин үеийн мэдлэг олгох тогтолцоог бүрдүүлэх зорилтын хүрээнд явагдаж байна.

Хүний үндсэн хэрэгцээний нэг болох сурч боловсрох хэрэгцээг хангах асуудал нь эргээд нийгмийн боловсролын хэрэгцээ болдог тул хүн бүр өөрийнхөө боловсрол, мэдлэг, дадал чадварт нийцүүлэн бие дааж ажил хөдөлмөр эрхлэх үндсэн дээр өөртөө болон нийгэмд үр өгөөжтэй байхаар өөрийгөө дайчлан ажиллаж, амьдрах шаардлага зүй ёсоор тавигдах учир хүний боловсролын тухай асуудал бидний зорьж буй нийгмийн чухал асуудал мөн. Хүний боловсролын хэрэгцээ тухайн хүний нийгэмд эзлэх байр суурь, гүйцэтгэх үүрэгтэй салшгүй холбоотой байх тул уг байр суурь, үүрэгт тохирох боловсрол олгох үйл ажиллагааг түүнтэй уялдсан менежментийн аргаар зохион байгуулна.

Аливаа шинжлэх ухаан өөрийн судалгаанд тулгуурладаг гол үндсэн ойлголттой байдгийн адил менежментийн ухаан байгууллага, түүнийг удирдах үйл ажиллагаанд гүйцэтгэх үүргийг эхлэн судалдаг. Байгууллагууд эрхлэх үйл ажиллагаа, гүйцэтгэж байгаа үүрэг, бусад олон үзүүлэлтээрээ өөр хоорондоо адилгүй байдаг боловч албан ёсоор байгууллага болон зохион байгуулагдсан нийтлэг нэг зүйл ажиглагддаг. Энэхүү нийтлэг зүйлийг судлахад менежментийн ухаан үүсч гарч ирсний гол учир шалтгаан оршино.

Үр дүнтэй менежмент гэдэг бол хамгийн үнэ цэнтэй зүйлийн нэг, амжилтын үндэс болохын хувьд улс орны хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулдаг чухал нөхцөл болдгийг судлаачид тогтоосон. Байгууллага бүр хөгжлийн илүү төвшинд хүрэхийн тулд зорилго, зорилтоо тодорхойлж, түүнд хүрэх арга замаа сонгодог нь стратегийн удирдлагын эхлэл болдог. Байгууллага үйл ажиллагааныхаа бүхий л хугацаанд зорилго зорилтоо зөв тодорхойлж, үр ашигтай ажиллах, үйл ажиллагаа өргөтгөх, зах зээлд найдвартай оршин тогтнох сонирхолтой байдаг нь тухайн байгууллагын стратегийн удирдлагын эх сурвалж байдаг. Эндээс дүгнэлт хийж үзвэл байгууллагын өсөлт, хөгжилт, тогтворжилт, зардлаа бууруулж, нөөцөө нэмэгдүүлэх асуудал стратегийн удирдлагын үндэс болно. Ийнхүү гадаад, дотоод орчины хувьсал, өөрчлөлтөд зохицуулж, байгууллагын холч давуу талыг улам бэхжүүлэх нэгдмэл цогцолбор зорилгыг **стратегу**, тодорхой онол, арга зүйн үндэслэлтэйгээр

